



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 86

Залаа

**Сумын хэмжээнд 2024 онд иргэнд өмчлүүлэх
газрын байршлыг тогтоох тухай**

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, иргэдийн саналыг үндэслэн 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Батлагдсан тогтоолыг Засгийн газарт уламжилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарын бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА **Н.ЖАРГАЛСАЙХАН**

648801094



Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
хуралдааны 2024 оны 07 дугаар сарын
26-ны өдрийн 26 дугаар тогтоолын
01 дүгээр хавсралт

2024 ОНД ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

№	Газрын байршил	Нийт иргэн	Газрын хэмжээ		Зориулалт
			м 2	га	
1	Өндөрлөг	7	4997	0,4997	Гэр бүлийн хэрэгцээнд
2	Эрүүл энх	2	1396	0,1396	Гэр бүлийн хэрэгцээнд
3	Бичил	1	382	0,0382	Гэр бүлийн хэрэгцээнд
4	Бэлийнхашаат	2	1505	0,1505	Гэр бүлийн хэрэгцээнд
5	Сүлдтолгой	1	722	0,0722	Гэр бүлийн хэрэгцээнд

_____ оОо _____